

Мэдлэгээ бататган давъя

А-1. Үгсийг бичихдээ аль дүрмийг хэрэглэн бичсэн байна вэ? Харгалзуулаарай.

- | | |
|-------------|--|
| 1. заадасла | А. Үгийн үндэс эвдрэх тул дүрмийг зөрчиж балархай эгшгийг ард нь бичдэг. |
| 2. нумла | Б. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагаврыг шууд залгаж бичнэ. |
| 3. захиал | В. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “л” дагаврыг залгахдаа эгшгийг ард нь бичнэ. |
| 4. шүдэл | Г. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагаврыг залгахдаа эгшгийг өмнө нь бичнэ. |

А-2. Эцэс + л, хувцас +л, зоргодос + л эдгээр үгсийг зөв бичсэн хувилбарыг сонгоорой.

- хувцасал
- хувцасла
- зоргодосол
- эцэслэ
- зоргодосло
- эцэсэл

А-3. Зөв бичсэн өгүүлбэрийг сонгоорой.

Дэвтрээ цэвэрхэн хавтасал.

Ном дэвтрээ хуудасла.

Учир шалтгааныг зөв үндэслэ.

Модыг хугачин залтасла.

Унаганыхаа зэлийг гадасал.

А-4. Алдаатай бичигдсэн бүлэг үгсийг сонгоорой.

А. гудасал

түргэл

балал

Б. зоргодосло

цүнхэл

аял

В. заадасла

сэнжэл

хариул

Г. хальсал

хуудасал

нүхэл

Д. гэдэслэ

өнгөл

ажилла

